



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/315

Булган сум

Богино хугацааны туршлага судлах арга хэмжээнд хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дүгээр зүйлийн 60.1.2, 60.1.9 дэх заалт, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны "Шинэ хөгжлийн зам" хөтөлбөрийг батлах тухай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны хуралдааны II/04 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны "Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг батлах тухай А/32 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хөх хотын эрүүл мэнд, сэргээн засах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эмнэлгийн болон нийгмийн халамж, хамгааллын тусламж үйлчилгээний тогтолцоо, соёл, спортын хөгжлийн чиг хандлагатай танилцах богино хугацааны туршлага судлах арга хэмжээнд оролцох албан хаагчдын нэрсийг 1 дүгээр, шаардагдах зардлыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Туршлага судлах арга хэмжээний зардал болох 17,340,000 (арван долоон сая гурван зуун дөчин мянга) төгрөгийг Эрүүл мэнд хөтөлбөрийн зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2024 оны
05 дугаар сарын 07 ны өдрийн АЗИС дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД УЛСАД БОГИНО ХУГАЦААНЫ ТУРШЛАГА СУДЛАХ АРГА
ХЭМЖЭЭНД ОРОЛЦОХ АЛБАН ХААГЧДЫН НЭРС

| д/д | Овог нэр | Байгууллага | Албан тушаал |
|-----|--------------------------------|--|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Мөнхбатын Батчимэг | Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс | Дарга |
| 2 | Амарсайханы Оюунжаргал | Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний бодлого зохьцуулалт хариуцсан мэргэжилтэн |
| 3 | Баатарсүрэнгийн Мягмарсүрэн | Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс | Хүн ам, нийгмийн бүлгүүдийн бодлого зохьцуулалт хариуцсан мэргэжилтэн |
| 4 | Ёндонжамцын Хулан | Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс | Соёл, спортын бодлого зохьцуулалт хариуцсан мэргэжилтэн |
| 5 | Чагнаадорж Энхбаяр | Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб | Цэргийн штабын дарга |
| 6 | Цэдэндамба Цэрэнтогтох | Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб | Дайчилгааны офицер |

Аймгийн Засаг даргын 2024 оны
05 дугаар сарын 07-ний өдрийн А/315 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт

БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД УЛСАД БОГИНО ХУГАЦААНЫ ТУРШЛАГА СУДЛАХ АРГА
ХЭМЖЭЭНД ХАМРАГДАХАД ШААРДАГДАХ ТӨСӨВ

| Д/д | Шаардагдах зардал | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Үнэ /төгрөг/ | |
|-----|--------------------|-------------|------------|--------------|------------|
| | | | | Нэг бүр | Нийт |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 1 | Замын зардлын багц | ш | 6 | 2,890,000 | 17,340,000 |